itools
ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

# АЙТҮҮЛС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2020.04.29

www.itools.mn itools.mn 7575 5585

# “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны
03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
..... дугаартай тогтоолын 3-р хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн **“COVID-19” коронавирусын халдвар дэгдсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цугларуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй** гэсэн мэдэгдлийн дагуу “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15 цагт **онлайнаар** зохион байгуулагдахаар боллоо.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр нь: 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байна.

**Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
- Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох,төсвийг батлах
- Компанийн дүрмийг шинэчлэн батлах
- Бусад

Хувьцаа эзэмшигчид хурлын материал, гарах шийдвэрийн төслүүд болон холбогдох баримт бичигтэй хамааралтай асуудлаар 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд өөрийн үйлчилгээ авч буй үнэт цаасны компаниуд болон “Айтүүлс” ХК-ийн оффисс-д буюу Мэдээллийн технологийн үндэсний паркын 103 тоотод ирж танилцах боломжтой.

Утас: **75755585**, **99059722**
И-мэйл: info@itools.mn, secretary@tuz.itools.mn

# ХЭХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР

itools
ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 19 өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 4 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн мэдэгдэл, "Айтүүлс" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Айтүүлс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагт онлайнаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, ХЭХурлын санал авах хуудас болон бусад холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.
3. Хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр тус тус томилсугай.
   - Хурал зохион байгуулах комисс:
     Дарга: Б.Ариунзул
     Гишүүд: Б. Хулан, Д. Билэгжаргал
   - Хурлын тооллогын комисс:
     Дарга: Л. Цэрэн-Очир
     Гишүүн: Э.Онон
4. Хурал зохион байгуулах ажлыг хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Ариунзул/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА [тамга: УЛААНБААТАР ХОТ, itools АЙТҮҮЛС ХК] А.БАТТАМИР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны
03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
..... дугаартай тогтоолын 5-р хавсралт

| # | ХӨТӨЛБӨР | ХАРИУЦАГЧ | ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА |
|---|---|---|---|
| 1 | Хурлын ирц бүртгэх | Зохион байгуулах комисс | 30 мин |
| 2 | Хурлын ирцийг мэдээлэх | Тооллогын комисс | 5 мин |
| 3 | Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах | Хурлын дарга | 10 мин |
| 4 | Айтүүлс ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх | Гүйцэтгэх захирал | 10 мин |
| 5 | Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах | ТУЗ | 5 мин |
| 6 | ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга хийх | Хурлын дарга | 5 мин |
| 7 | ТУЗ-ийн 2020 оны төсвийг танилцуулах | Хурлын дарга | 5 мин |
| 8 | Компанийн дүрэмд орох өөрчлөлтийг хэлэлцэх | Хурлын дарга | 15 мин |
| 9 | Их хэмжээний хэлцэл хийх тухай танилцуулах | Хурлын дарга | 5 мин |
| 10 | Асуулт, хариулт | Хурлын дарга | 30 мин |
| 11 | Санал хураалт | Тооллогын комисс | 30 мин |
| 12 | Хурлын завсарлага, санал тоолох | Зохион байгуулах комисс, Тооллогын комисс | 30 мин |
| 13 | Санал хураалтын дүнг танилцуулах | Тооллогын комисс | 10 мин |
| 14 | Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах | Хурлын дарга | 5 мин |
| 15 | Хурлыг хаах | Хурлын дарга | 5 мин |

Хурлын үргэлжлэх хугацаа: **3.30 цаг**
**Жич:** Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагч байгууллагууд та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

Хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологийн салбартай хөл нийлүүлэн, мөр зэрэгцэн алхаж, хором мөч бүртэй уралдан ажиллаж, судалгаа шинжилгээнд үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээндээ сайжруулалт хийж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалж, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарласан, салбартаа тэргүүлэгч компани гэдгээ дахин нотлон ажилласан жил байлаа.

2019 онд Хөрөнгийн бирж дээр нийт 254 өдрийн арилжаа явагдсанаас компанийн хувьцаа 223 өдөр буюу 87.8%-д идэвхтэй арилжаалагдсан байна. Бид 2019 оны санхүүгийн төсөөлөл, төлөвлөгөөндөө хүрч чадсан амжилт дүүрэн жил байлаа. Жилийн борлуулалтын орлого 3,1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 106.2%-иар, цэвэр ашгийн хэмжээ 206 сая төгрөгт хүрч 20.3%-иар тус тус өссөн.

Монгол улсад бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж, дижитал шилжилтийг хурдацтай хийж байна. Бид өөрсдийн мянга мянган харилцагчиддаа зориулан шинэ үеийн дэвшилтэт технологиудыг шингээсэн суурь системийг бий болгосон нь Мэдээллийн технологийн салбарын хөгжил төдийгүй Монгол улсын дижитал шилжилтэнд оруулсан томоохон хувь нэмэр юм. Дэлхий нийтийн дата төвийн технлгийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, Монголдоо анхдагч Клауд технологид суурилсан ICS бүтээгдэхүүнээ 2019 оны 9 сард ашиглалтанд оруулав.

> *Жилийн борлуулалтын орлого 3,1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 106.2%-иар, цэвэр ашгийн хэмжээ 206 сая төгрөгт хүрч 20.3%-иар тус тус өссөн.*

2018 онд ашиглалтан орсон Санхүүгийн дата төвийн аюулгүй байдлыг сайжруулах, үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн ажиллах зорилго тавьсаны хүрээнд тус дата төвд Олон улсын төлбөр тооцооны стандарт PCI DSS-ийг Level 1 хүрээнд 2019 оны 6 сард амжилттай нэвтрүүлж, Мэдээллийн аюулгүй байдлаа сайжруулан ажиллалаа.

Өнгөрсөн онд Дархан-Уул аймагт байрлалтай Блокчейн дата төвөөрөө дамжуулан дотоод болон гадаадын компаниудтай амжилттай хамтран ажиллав.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
**Б.ТАМИР**

"Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаас ногдол ашиг хувиарлах эсэх тухай хэлэлцсэн бөгөөд Компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, Үндэсний клауд үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байх нь зүйтэй хэмээн хуралд оролцсон ТУЗ-ын гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэсэн.

Гүйцэтгэх захирлын хувьд мэдээллийн технологийн салбарын цаг минутаар хэмжигдэн хөгжиж буй энэ үед компаний ирээдүйн ашиг орлого, зах зээлийн өсөлтөнд чухал ач холбогдол бүхий нүдээ олсон шийдвэр байлаа гэж үзэж байна. 2020 онд компанийнхаа ашиг орлогыг улам нэмэгдүүлж, компанийн сайн засаглалыг улам батжуулж, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг бүрэн хангаж, бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллахаа хариуцлагатайгаар та бүхэндээ мэдэгдэж байна. Мэдээллийн технологийн салбарын хөгжил, Монгол Үндэстний мэдээллийн аюулгүй байдлыг хангах их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан манай компанид хөрөнгө оруулалт хийсэн та бүхэндээ баярлалаа.

## 2019 ОНЫ ӨСӨЛТҮҮД

**НИЙТ ХЭРЭГЛЭГЧИД**
**7'790**

**ӨСӨЛТИЙН ХУВЬ**
**26.8 %**

## БОРЛУУЛАГДСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОО




**ӨСӨЛТИЙН ХУВЬ**
**18.8 %**

# 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

02 САР

### САНХҮҮГИЙН ДАТА ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ БҮРЭН ДУУСЧ, АШИГЛАЛТАД ОРЛОО

Аливаа байгууллагын урт хугацаанд тогтвортой, амжилттай ажиллах нэг гол хүчин зүйл нь харилцагчийн дата болон мэдээллийн технологийн шийдэл, дэд бүтэц байдаг. Ялангуяа санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллага бүрт харилцагчийнхаа мэдээллийг Монгол Улсдаа хадгалах хэрэгцээ зайлшгүй тулгардаг. Тус хэрэгцээ шаардлагын хүрээнд манай компани нь Улаанбаатар хот дахь дата төвийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн ААНБ-ууд, банк санхүү, брокер диллер, даатгал зэрэг бизнесийн салбаруудын өгөгдлийн найдвартай хадгалахад чиглэсэн орчин үеийн дата төвийн чиг хандлагад тулгуурласан “Санхүүгийн Дата Төв”-ийг бүрэн ашиглалтанд оруулаа.



04 САР

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ЭЭЛЖИТ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49 Мэдээллийн технологийн үндэсний паркийн хурлын танхимд боллоо. Тус хурлаар компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн үзүүлэлтүүдийн талаар танилцуулагдаж, нийт 5 асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэлээ.

05 САР

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭР “СИНЭТ” ХХК НЬ “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ОХИН КОМПАНИ БОЛЛОО

21-р зууныг интернетгүйгээр төсөөлөхийн аргагүй юм. Мөн дата төвийн үйлчилгээний түүхий эд нь интернет байдаг. ХЭХ-ын шийдвэрээр интернетийн үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьцаа эзэмшигч болсон нь бидний үйл ажиллагааны явцыг хурдасгах хөшүүрэг боллоо. Бид цаашлаад байгууллагын онцлог, интернетийн хэрэгцээ шаардлагаас хамаарч зөвхөн байгууллагад зориулсан хамгийн найдвартай, өндөр хурдны интернетийн үйлчилгээг санал болгох боломж бүрдлээ.

05 САР

### ДАРХАН ХОТОД ДЭД БҮТЭЦ НЬ БҮРЭН ШИЙДЭГДСЭН, АШИГЛАЛТАД ОРСОН 1300 М2 ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН БАЙРТАЙ БОЛЛОО

Бид өнгөрсөн оны 9 дүгээр сараас эхлэн Дархан хотод байрлах АйСиТи Групп ХХК-ийн байранд “Блокчейн Дата төв”-ийн үйл ажиллагаагаа эхлүүлж байсан билээ. Тус үйлчилгээний гол хэрэглэгчид нь Япон Улсад бүртгэлтэй, үйл ажиллагаа нь олон нийтэд танигдсан групп компаниуд байдаг. Тэгвэл ХЭХ-ын шийдвэрээр дархан хотод байрлах дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, ашиглалтад бүрэн орсон тус барилга, байгууламж нь Айтүүлс ХК-ийн эзэмшилд шилжлээ. Уг барилгыг эзэмшсэнээр дархан хотод дата төвөө богино хугацаанд нэх боломж бүрдлээ.



06 САР

### PCI DSS СТАНДАРТЫН LEVEL1 ТӨВШИНГ ХАНГАЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ

Энэхүү стандарт нь тухайн байгууллагын хэрэглэгчийн төлбөр тооцооны мэдээлэлд хэрхэн хандах, боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагааг аргачилсан баримт бичгийн бүрдэл юм. Стандартын шаардлагуудыг бүрэн хангасны үндсэн дээр хэрэглэгчийн төлбөр тооцооны мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдлага, эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэх, яаралтай арга хэмжээ авах, учирсан хохирлыг тооцоолох боломж бүрдэж байгаа юм. Дата төвийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд стандартыг Монголдоо анх удаа хангасанаараа онцлогтой ба тус стандартын баталгаажуулалтыг дэлхийд 3-т ордог “Trust Wave” ОУ-ын компани хийсэн нь өндөр ач холбогдолтой байлаа.

09 САР

### МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГҮНЗГИЙРҮҮЛСЭН СУРГАЛТТАЙ “NEST” АХЛАХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ УРТ ХУАЦААНЫ “СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ”-ИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Урт хугацааны стратегийн тус гэрээний хүрээнд сурагчдын мэдээлэл технологийн сонирхол, боловсролыг нэмэгдүүлэх, олон нийтэд сурталчлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх ба “Айтүүлс” ХК шаардлагатай технологи, програм хангамж, үйлчилгээгээр ханган ажиллах юм. Энэхүү үйл явдал нь Мэдээллийн технологийн салбарийн цаашдын хүний нөөцийн асуудалд үнэтэй хувь нэмэр оруулах болно.



## 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

09 САР

### МОНГОЛ УЛСДАА АНХДАГЧ ҮҮЛЭН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТ ТОХИОВ.

**"ICT expo-2019"** Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр Айтүүлс ХК нь Монгол инженерүүдийн инноваци шингэсэн оюуны бүтээл болох үндэсний хэмжээний анхны үүлэн технологид суурилсан "**Itools Cloud Service**" буюу **ICS** үйлчилгээгээ танилцуулж, нээсэн нь салбарын мэргэжилтнүүдэд төдийгүй орчин цагийн мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн 98 жилийн түүхэнд онцлох үйл явдал боллоо. Энэхүү бүтээгдэхүүн нь хэрэглэгчидэд энгийн ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, цаг зав хэмнэсэн, үян хатан тохируулгуудаас гадна санхүүгийн бодит хэмнэл үзүүлэх, хэрэглэснээрээ төлбөрөө төлөх бүрэн боломжтойгоороо давуу талтай юм.



09 САР

### ШИЛДЭГ ТЕХНОЛОГИ, ШИЙДЭЛ НЭВТРҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГААР ШАЛГАРАВ.

Засгийн газрын тохируулагч агентлаг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас жил бүр зохион байгуулдаг "ICT EXPO" нь 13 дахь жилдээ 2019 оны 09 дүгээр сарын 27-29-ны өдрийн хооронд "Дижитал хөгжилд хамтдаа " уриан дор амжилттай зохион байгуулагдлаа. Мэдээллийн технологийн шинэ шийдэл, бүтээгдэхүүнүүд танилцуулагддаг үзэсгэлэн арга хэмжээнд Шилдэг технологи, шийдэл нэвтрүүлэгч байгууллагаар "Айтүүлс" ХК тодорлоо.



09 САР

### "ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ"-ИЙГ АМЖИЛТТАЙ ХӨГЖҮҮЛЭВ.

Бодлогын баримт бичгийн уялдаа холбоог сайжруулж, бодитоор хэрэгжүүлэх, төрийн албаны залгамж халааг бэхжүүлэх, мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, албан ёсны нэгдсэн мэдээллийн эх үүсвэрээс шаардлагатай мэдээллээ цаг тухайд нь авч, бодлого, төлөвлөлтдөө тусгах, иргэд, олон нийт, гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн албаны үйл ажиллагаа ойлгомжтой, нээлттэйгээр мэдээлэх зэрэг олон давуу талыг бий болгох юм.



**ЗОГСОЛТГҮЙ**
**ХӨГЖИЖ,**
**АМЖИЛТААРАА**
**ЯЛГАРЪЯ**

# ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

## 1) ITOOLS CLOUD SERVICE

Монголдоо анхдагч Үндэсний хэмжээний үүлэн технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүллээ. Үүлэн технологид суурилсан вэб байршуулах үйлчилгээ нь олон тооны серверүүд нь нэг том сервертэй адилхан ажиллах боломжийг олгодог онцлогтой шинэ технологи юм.

**Үүлэн технологид суурилсан "Ай Си Эс" үйлчилгээ нь дараах давуу талуудтай байна.**

- "Ай Си Эс" үйлчилгээ нь хэрэглээнээс хамааран төлбөр бодогддог, хэрэглэгчийн хувьд найдвартай үйлчилгээг илүү хямд үнээр ашиглах боломжтой.
- Дата төвийн үйлчилгээг ашиглахад байгууллагуудад серверийн асуудлууд, дата хадгалалт, өгөгдлийн сан, аппликейшин сервер, интернет гээд маш олон асуудлууд байдаг билээ. Үүлэн технологид дээр суурилсан "Ай Си Эс" вэб байршуулах үйлчилгээг ашигласнаар ямар нэгэн асуудалд санаа зовох зүйлгүй веб сайт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг зэрэг бусад асуудлууддаа л үнэт цагаа зарцуулах боломжтой болно. Үүлэн технологид суурилсан байршуулах үйлчилгээг ашигласнаар танд тулгардаг технологийн асуудлуудыг бид бүрэн шийдэх болно.
- Үүлэн технологид суурилсан "Ай Си Эс" үйлчилгээ нь таны дата, мэдээллийг онлайн орчинд олон газар зэрэг байршуулснаар мэдээлэл алдагдах эрсдлээс бүрэн хамгаалагдах боломжтой юм.
- Үүлэн технологид суурилсан тус үйлчилгээ нь хэрэглэгч таны бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийд гаргаад зогсохгүй, цаашид бизнес өргөжин, хэрэглэгчид нэмэгдэж ачаалал ихсэх үед динамик (уян хатан) байдлаар системийн хүчин чадлыг өөрийн хэрэгцээнд тохируулан системээ шууд өргөжүүлээд явах боломжийг олгодогоороо маш том давуу талтай.




itools CLOUD SERVICES

## 2) ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

**"Айтүүлс" ХК** болон **Үндэсний хөгжлийн газар**, **Азийн хөгжлийн банктай** хамтарсан "*Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх*" төслийн хэрэгжүүлэгчээр амжилттай ажиллалаа. Уг төслийн хүрээнд төрийн үйлчилгээний салбар бүрийн болон орон нутгийн, үндэсний түвшний бодлого боловсруулагч нарын өдөр тутмын ажлыг орчин үеийн технологийн дэвшилтэд аргаар системжүүлэн нэгдсэн мэдээллийн систем үүсгээд байна.

Ингэснээр бодлогын баримт бичгийн уялдаа холбоог сайжруулж, бодитоор хэрэгжүүлэх, төрийн албаны залгамж халааг бэхжүүлэх, мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, албан ёсны нэгдсэн мэдээллийн эх үүсвэрээс шаардлагатай мэдээллээ цаг тухайд нь авч, бодлого, төлөвлөлтдөө тусгах, иргэд, олон нийт, гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн албаны үйл ажиллагаа ойлгомжтой, нээлттэйгээр мэдээлэх зэрэг олон давуу талыг бий болгох юм.



# ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

## 3) БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООНЫ ИЖ БҮРЭН СИСТЕМ

**"Хөдөө аж ахуйн бирж"** ТӨХХК-тэй хамтран блокчейн технологид суурилсан арилжаа төлбөр тооцооны иж бүрэн системийг хөгжүүлэх төслийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тус төсөл нь хөдөө аж ажуйн гаралтай түүхий эдийн арилжааны нэгдсэн систем бөгөөд арилжааг цахимжуулж, бараа, түүхий эдийн зах зээлийн өнөөгийн нөхцөл боломж, онцлогоос шалтгаалан худалдагч, худалдан авагч талуудын бараа, түүхий эд худалдах, худалдан авах гэрээг үндэслэн төлбөр тооцоо хийж гүйцэтгэх буюу хоёр талт клирингийн зарчмаар төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээг үзүүлдэг.

Арилжаанд оролцохыг хүссэн хүн бүр iOS болон Android үйлдлийн системтэй гар утсаа ашиглан, хүссэн газраасаа бүртгүүлж, биржийн арилжаанд оролцох боломжтойгоороо давуу талтай юм.

- Хялбар хэрэглээ
- Олон улсын стандарт
- Аюулгүй байдал



# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

ҮҮАБО /ДАТА ТӨВ/ 8,92% ↑

ҮҮАБО /БЛОКЧЭЙН ТӨВ/ 148,8% ↑

ТЕНДЕР ОРЛОГО 418,41% ↑

ҮБҮАО 379,9% ↑




## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО 106,2% ↑

ББӨ 298,91% ↑

ЦЭВЭР АШИГ 20,27% ↑



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН /АУДИТЛАГДСАН/



## 2. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ

| Үзүүлэлт | Тодруулга | 2018.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| **1. Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 8.1. | 28,763,843.20 | 74,549,059.78 |
| Дансны авлага | 8.2. | 181,146,590.54 | 1,191,941,599.92 |
| Бусад авлага | 8.3. | 321,188,924.98 | 14,319,134.85 |
| Бараа материал | 8.4. | 90,355,536.92 | 106,531,745.03 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 8.5. | 520,510,397.89 | 244,705,357.81 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **1,141,965,293.53** | **1,632,046,897.39** |
| **2. Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 8.6. | 2,256,421,417.02 | 1,471,806,885.29 |
| Биет бус хөрөнгө | 8.7. | 132,249,430.91 | 124,289,390.91 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 8.8. | 70,446,145.00 | 70,446,145.00 |
| Дуусаагүй барилга | 8.9. | | 1,008,172,180.44 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **2,459,116,992.93** | **2,674,714,601.64** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **3,601,082,286.46** | **4,306,761,499.03** |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | | |
| **1. Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Дансны өглөг | 8.10. | 60,175,907.30 | 86,486,613.79 |
| Цалингийн өглөг | 8.11. | 3,918,681.22 | - |
| Татварын өглөг | 8.12. | 121,357,313.20 | 95,313,159.95 |
| НДШ-ийн өглөг | 8.13. | 3,165,291.79 | - |
| Ногдол ашгийн өглөг | 8.14. | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 8.15. | 173,168,708.51 | 624,329,713.18 |
| Урьдчилж орсон орлого | 8.16. | 245,745,030.17 | 301,049,901.31 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **607,530,932.20** | **1,107,179,388.23** |
| **2.Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Хойшлогдсон татварын өр | | | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | - | - |
| **Өр төлбөрийн нийт дүн** | | **607,530,932.20** | **1,107,179,388.23** |
| **Эзэмшигчдийн өмч** | | | |
| Өмч: а) Хувийн | 8.17. | 905,758,223.28 | 905,758,223.28 |
| б) хувьцаат | 8.17. | 1,338,798,000.00 | 1,338,798,000.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц | 8.17. | 460,721,652.19 | 460,721,652.19 |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | 8.17. | 288,273,478.79 | 494,304,235.34 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | | **2,993,551,354.26** | **3,199,582,110.81** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **3,601,082,286.46** | **4,306,761,499.03** |

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
хуудас ...

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН /АУДИТЛАГДСАН/



**2.2. ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН**

**БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

| Үзүүлэлт | Тодруулга | 2018.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 8.18. | 1,512,815,765.71 | 3,086,784,553.85 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 8.18. | 597,985,826.33 | 2,385,417,057.62 |
| **Нийт ашиг (алдагдал)** | | **914,829,939.38** | **701,367,496.23** |
| Түрээсийн орлого | 8.18. | 10,909,090.91 | 19,319,788.18 |
| Хүүгийн орлого | 8.18. | 428,578.78 | 1,047,983.03 |
| Ногдол ашгийн орлого | | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | | - | - |
| Бусад орлого | 8.19. | 162,250.61 | 34,739,758.37 |
| Борлуулалт маркетингийн зардал | | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 8.20. | 742,679,505.80 | 508,025,927.46 |
| Санхүүгийн зардал | | - | - |
| Бусад зардал /УАБЗ/ | 8.21. | 7,732,045.00 | 18,153,957.24 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/ | 8.21. | 5,945,174.58 | 2,556,469.40 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | 8.21. | 9,331,455.45 | (1,911,441.31) |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | | - | - |
| Бусад ашиг /алдагдал/ | | - | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | | **191,194,938.91** | **230,940,169.20** |
| Орлогын татварын зардал | 8.22. | 19,892,698.39 | 24,909,412.61 |
| Хойшлогдсон татварын зардал /орлого/ | | - | - |
| **Татварын дараах ашиг /алдагдал/** | | **171,302,240.52** | **206,030,756.56** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/ | | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал )** | | **171,302,240.52** | **206,030,756.56** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүний нөөц | | - | - |
| Бусад олз /гарз/ | | - | - |
| **Орлогын нийт дүн** | | **171,302,240.52** | **206,030,756.56** |

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
хуудас ...

## 2.3. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,244,556,223.28 | 460,721,652.19 | 116,971,238.27 | 2,822,249,113.74 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 2,244,556,223.28 | 460,721,652.19 | 116,971,238.27 | 2,822,249,113.74 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | 171,302,240.52 | 171,302,240.52 |
| Өмчит гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,244,556,223.28 | 460,721,652.19 | 288,273,478.79 | 2,993,551,354.26 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 2,244,556,223.28 | 460,721,652.19 | 288,273,478.79 | 2,993,551,354.26 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | 206,030,756.55 | 206,030,756.55 |
| Өмчит гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,244,556,223.28 | 460,721,652.19 | 494,304,235.34 | 3,199,582,110.81 |

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
6 хуудас ...

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН /АУДИТЛАГДСАН/



## 2.4. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Үзүүлэлт | 2018.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|
| **1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 1,372,857,881.66 | 3,033,214,758.05 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,364,966,032.05 | 2,654,913,061.87 |
| Бусад мөнгөн орлого | 7,891,849.61 | 378,301,696.18 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 1,423,608,626.87 | 2,789,160,803.51 |
| Ажиллагчдад төлсөн | 207,139,725.30 | 281,288,274.37 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 55,636,917.06 | 82,552,508.94 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 467,504,826.36 | 1,486,393,842.43 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 108,879,938.60 | 172,974,297.56 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,999,666.37 | 4,283,489.86 |
| Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө | - | 2,750,000.00 |
| Татварын байгууллагад төлсөн | 47,794,388.24 | 324,656,918.44 |
| Бусад мөнгөн зарлага | 533,653,164.94 | 434,267,471.91 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(50,750,745.21)** | **244,047,954.54** |
| **2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 27,871,976.11 | 158,113,561.45 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 140,000.00 | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 27,303,397.33 | 157,445,019.50 |
| Хүлээн авсан хүүний орлого | 428,578.78 | 668,541.95 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 434,235,527.50 | 457,740,846.77 |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 338,821,811.00 | 310,932,037.69 |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 95,413,716.50 | 146,808,809.08 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(406,363,551.39)** | **(299,627,285.32)** |
| **3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 124,022,327.65 | 364,295,286.00 |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 124,022,327.65 | 364,295,286.00 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 56,098,120.00 | 266,372,088.54 |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 56,098,120.00 | 266,372,088.54 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **67,924,207.65** | **97,923,197.46** |
| Валютын ханшийн зөрүү | 5,945,174.58 | 3,441,349.90 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(383,244,914.37)** | **45,063,185.51** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **412,008,757.57** | **28,763,843.20** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **28,763,843.20** | **74,549,059.78** |

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
хуудас ...

# НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР

itools
ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 17 өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1,2,5 дахь заалтууд, “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, “ICS клауд” системийг сайжруулах мөн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны ашигаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б. Ариунзул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА — А. БАТТАМИР

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС ХК

# 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 17 өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.11 дэх заалт, “Айтүүлс” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж үзсүгэй.

2. Тайлангийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсугай.

УЛААНБААТАР ХОТ АЙТҮҮЛС ХК 1116218269 ш.5428361

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА А.БАТТАМИР

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Адилбиш**
- Өөрийн нэр: **Баттамир**
- Төрсөн огноо: 1982-09-15
- Төрсөн газар: Улаанбаатар хот
- Регистрийн дугаар: ЧЕ82091538
- Гэрийн хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 39/61 тоот
- Утасны дугаар: 9910-6605

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| ШУТИС-МХТС | Улаанбаатар | 2016 | 2018 | Техникийн ухааны магистр |
| ШУТИС-МХТС | Улаанбаатар | 1998 | 2003 | Програм хангамж |
| Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургууль | Улаанбаатар | 1995 | 1998 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Ай Дэйм ХХК | Гүйцэтгэх захирал | 2018 оноос хойш |
| Ай Си Ти Групп ХХК | Технологи хариуцсан захирал | 2016-2017 |
| Ай Си Ти Групп ХХК | Гүйцэтгэх захирал | 2014-2016 |
| Айтүүлс ХХК | Гүйцэтгэх захирал | 2012-2014 |
| Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам | Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх | 2011-2012 |
| Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо | Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх | 2009-2011 |
| Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв | Програмист | 2002-2009 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Баярмагнай**
- Өөрийн нэр: **Эрдэнэжаргал**
- Төрсөн огноо: 1986-10-28
- Төрсөн газар: Сэлэнгэ аймаг, Хүдэр сум
- Регистрийн дугаар: МП86102872
- Гэрийн хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, 84Б байр, 5 тоот
- Утасны дугаар: 9907-2783

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| ШУТИС-КТМС | Улаанбаатар | 2004 | 2008 | Бизнесийн удирдлагын бакалавр |
| 3-р сургууль | Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум | | 2004 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Стандарт инвестмент ҮЦК ХХК | Диллер | 2012 оноос хойш |
| Хера холдинг ХХК | Судалгааны ажилтан | 2009 - 2012 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Нанжид**
- Өөрийн нэр: **Улаанхүү**
- Төрсөн огноо: 1982-10-20
- Төрсөн газар: Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум
- Регистрийн дугаар: МП82102011
- Гэрийн хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 13-р хороо, 127/4 - 5 тоот
- Утасны дугаар: 9910-3720

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| МУИС-ЭЗС | Улаанбаатар | 2000 | 2005 | Эзийн засгийн онол, эдийн засагч |
| 1-р сургууль | Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум | 1990 | 2000 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Айсити групп ХК | Санхүү хариуцсан захирал | 2020.04.01-нээс |
| Айсити групп ХХК | Гүйцэтгэх захирал | 2019 - 2020 |
| Стандарт финаншл групп ХХК | Гүйцэтгэх захирал | 2014 - 2019 |
| Монет капитал ҮЦК ХХК | Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлах | 2010 - 2014 |
| Анод банк | Эрсдэлийн шинжээч | 2007 - 2009 |
| Дэлхийн банк, Тогтвортой амьжиргаа төсөл | Судалгааны мэргэжилтэн | 2005 - 2006 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Баярсайхан**
- Өөрийн нэр: **Тамир**
- Төрсөн огноо: 1987-05-03
- Төрсөн газар: Улаанбаатар хот
- Регистрийн дугаар: ЕП87050309
- Гэрийн хаяг: УБ, Баянгол дүүрэг, 8-р хороо,3-р хороолол 42 - 58 тоот
- Утасны дугаар: 9999-8397

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| "Фатих" Их сургууль | БНТУ | 2013 | 2014 | Мастер-Улс төрийн удирдлага |
| МУИС | Улаанбаатар | 2006 | 2010 | Бакалавр-Хятад судлаач, багш |
| Монгол туркын хамтарсан сургууль | Улаанбаатар | 2003 | 2006 | Бүрэн дунд |
| 97-р дунд сургууль | Улаанбаатар | 1995 | 2003 | Бүрэн бус дунд |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| АйТүүлс ХК | Гүйцэтгэх захирал | 2018 |
| Эмпасофт ХХК | Сургалт хариуцсан менежер | 2016 - 2018 |
| Гааль Татварын мэдээллийн технологийн төв УТҮГ | Олон нийттэй харилцах мэргэжилтэн | 2016 |
| Татварын Ерөнхий газар-НӨАТ-ын тэсөл | Ерөнхий санхүүч | 2014 - 2016 |
| Улаанбаатар-Элит ОУДС | Нягтлан бодогч | 2014 |
| Эмпати-Ертөнц ХХК | Нягтлан бодогч | 2012 - 2013 |
| Саман-Ёлу ХХК | Захирлын туслах | 2010 - 2012 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Гантулга**
- Өөрийн нэр: **Хатанболд**
- Төрсөн огноо: 1986-06-21
- Төрсөн газар: Хөвсгөл аймаг, Тариалан сум
- Регистрийн дугаар: РЙ86062111
- Гэрийн хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Голомт хотхон, А байр 14 тоот
- Утасны дугаар: 9910-6970

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| МУИС-ХЗС | Улаанбаатар | 2015 | 2018 | Эрх зүйч |
| ШУТИС-КтМС | Улаанбаатар | 2003 | 2007 | Санхүү удирдлага |
| Хөвсгөл, Тариалан 10-н жил | Хөвсгөл, Тарилан сум | 1994 | 2003 | Бүрэн дунд |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Айсити групп ХК | Гүйцэтгэх захирал | 2020.04.01-нээс |
| Дижитал Эксчейнж Монголиан ХХК | Гүйцэтгэх захирал | 2018 - 2020 |
| Стандарт капитал ХХК | Дэд захирал | 2012 оноос хойш |
| Хера холдинг ХХК | Судалгааны ахлах ажилтан | 2009 - 2012 |
| Лайфтайм инвестмент ҮЦК ХХК | Брокер, диллер | 2007 - 2008 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Даваасүрэн**
- Өөрийн нэр: **Батцэцэг**
- Төрсөн огноо: 1983-12-10
- Төрсөн газар: Өверхангай аймаг, Дэлгээн хороо
- Регистрийн дугаар: ЙУ83121009
- Гэрийн хаяг: УБ, Хануул дүүрэг, 4-р хороо, 1204-74 тоот
- Утасны дугаар: 9907-3101

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| МЭЭИС | Архангай | 2005 | 2007 | Нягтлан бодогч |
| МУШУТИС | Улаанбаатар | 2001 | 2005 | Математик загварчлал |
| Хүмүүн цогцолбор 1-р сургууль | Архангай аймаг, цэцэрлэг хот | 1991 | 2001 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Ай Си ти групп ХК | Ерөнхий нягтлан бодогч | 2019 оноос хойш |
| АПУ Трейдинг ХХК | Аудитор | 2012-2019 |
| Эх Голомтын Илч ХХК | Ерөнхий нягтлан бодогч | 2007-2012 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Лхагва**
- Өөрийн нэр: **Тэмүүлэл**
- Төрсөн огноо: 1982-06-21
- Төрсөн газар: Улаанбаатар хот
- Регистрийн дугаар: ЧР82062177
- Гэрийн хаяг: УБ, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 37-55 тоот
- Утасны дугаар: 9611-5000

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| Канберра хотын их сургууль | Канберра хот, Австрали улс | 2011 | 2012 | Эрх зүйн ухааны магистр |
| Төв Куйнзлэндийн их сургууль | Сидней хот, Австрали улс | 2003 | 2006 | Бизнесийн удирдлагын бакалавр |
| Нийслэлийн 1-р дунд сургууль | Улаанбаатар | 1997 | 1999 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Тэлмэнхас ББСБ | Хувьцаа эзэмшигч | 7 жил |
| ХААН банк | Ахлах хуулийн зөвлөх | 5 жил |
| Монголын Хөрөнгийн Бирж | Гадаад харилцааны мэргэжилтэн | 2 жил |
| Asia Pacific Investment Partners | Арилжааны брокер | 1 жил |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Зэсэм**
- Өөрийн нэр: **Мягмарсүрэн**
- Төрсөн огноо: 1967-03-30
- Төрсөн газар: Төв аймаг, Сэргэлэн сум
- Регистрийн дугаар: НС67033060
- Гэрийн хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг, 18-р хороо, Цолмонгийн 4-31 тоот
- Утасны дугаар: 9908-0074

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| Санхүү эдийн засгийн дээд сургууль | Улаанбаатар | 2000 | 2003 | Бизнесийн Удирдлага, зах зээл судлаач эдийн засагч |
| ММНБИ | Улаанбаатар | 2000 | 2003 | Аудитор |
| ММНБИ | Улаанбаатар | 1995 | 2003 | Мэргэшсэн нягтлан бодогч |
| Санхүү эдийн засгийн техникум | Улаанбаатар | 1985 | 1987 | Нягтлан бодогч,эдийн засагч |
| Ерөнхий боловсролын сургууль | Төв аймаг | 1975 | 1985 | |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Бодьтусгал-Аудит ХХК | Захирал | 2011-оноос хойш |
| Нийслэл-Аудит ХХК | Ахлах аудитор | 2005-2011 |
| ЭсЭм-Аудит ХХК | Төв аймгийн салбарын захирал | 2003-2005 |
| Эрдэнэ ҮҮГ | Ерөнхий ня-бо | 1989-2003 |
| Төв аймгийн Сэргэлэн сум ХБА | Нягтлан бодогч | 1987-1989 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Дамдинсүрэн**
- Өөрийн нэр: **Даваа**
- Төрсөн огноо: 1981-11-09
- Төрсөн газар: Говь - Алтай, Алтай сум
- Регистрийн дугаар: ТА81110919
- Гэрийн хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Оршил 22 тоот
- Утасны дугаар: 9911-1633

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГСӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| ШУТИС | Улаанбаатар | 1998 | 2002 | Мэдээллийн технологи |
| 15-р сургууль | Дархан-Уул аймаг | 1989 | 1998 | |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| ККТТ ХХК | Гүйцэтгэх захирал | 2016.01 – одоо |
| Цагдаагийн ерөнхий газар | Төлөөлөгч, ахлах төлөөлөгч, тасгийн дарга, хэлтсийн дарга, төвийн дарга | 2001.04 – 2014.07 |

# АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

## 1) Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл



- Эцэг /Эх/ -ийн нэр: **Энхтуяа**
- Өөрийн нэр: **Наранмөнх**
- Төрсөн огноо: 1987-03-04
- Төрсөн газар: Улаанбаатар хот
- Регистрийн дугаар: ХА87030411
- Гэрийн хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 5-128 тоот
- Утасны дугаар: 9905-4120

## 2) Боловсролын талаарх мэдээлэл

| ТӨГССӨН СУРГУУЛЬ | ХААНА | ЭЛССЭН ОН | ТӨГССӨН ОН | ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ |
|---|---|---|---|---|
| ШУТИС-КТМС | Улаанбаатар | 2003 | 2007 | Програм хангамжийн инженер |
| ШУТИС-Математикийн лицэй | Улаанбаатар | 2001 | 2003 | Бүрэн дунд боловсрол |

## 3) Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

| АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР | АЛБАН ТУШААЛ | АЖИЛЛАСАН ХУГАЦАА |
|---|---|---|
| Greensoft | Head of sales & Marketing | 2016- оноос хойш |
| Новасофт ХХК | Head of sales & Marketing | 2013-2016 |
| Гацуурт трейд | Co founder & Dealer | 2011-2013 |
| Asia pacific investment partners | Webmaster | |

# АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Айтүүлс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
хурлын ..... дүгээр тогтоолын ..... хавсралт

**“АЙТҮҮЛС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 “АЙТҮҮЛС” компани нь нээлттэй хувьцаат компани (цаашид “компани” гэж нэрлэх) мөн бөгөөд Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Компанийн оноосон албан ёсны нэр нь доор заасны дагуу байна.

1.2.1 Монгол хэлээр: “АЙТҮҮЛС” Хувьцаат компани
1.2.2 Англи хэлээр: “ITOOLS” Joint Stock Company

1.3 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, 34-р байр, 2 тоот.

1.4 Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.5 Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

1.6 Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэж нэрлэх) баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн “АЙТҮҮЛС” ХК эдэлнэ.

1.7 Компани нь үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.

1.8 Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

1.9 Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

**ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

2.1 Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, компанийн логотой байх ба Компани нь банкинд төгрөгийн, гадаад валютийн болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

2.2 Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

2.3 Хувьцаа эзэмшигчид Компанийн хариуцлагыг хүлээхгүй ба Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

2.4 Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

# АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1 Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

3.2 Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:

3.2.1 Программ хангамжийн үйлчилгээ;
3.2.2 Мэдээллийн технологийн үйлчилгээ;
3.2.3 Гадаад худалдаа;
3.2.4 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.

3.3 Компани нь энэ дүрмийн 3.2-т заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно.

3.4 Монгол улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхлэнэ.

3.5 Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

### ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

4.1 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 43 (дөчин гурав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 34,452,124 (гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорин дөрөв) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

4.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,481,441,332 (нэг тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун гучин хоёр) төгрөг байна.

4.3 Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.

4.4 Компанийн нийт хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрт өөрчлөгдөнө.

4.5 Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд ТУЗ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах (хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар) тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласанаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.6 Шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

**"АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ**

5.2.5.1 нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх

5.2.5.2 компанийн тухай хуулийн 87.1.1, 87.1.2-т заасан их хэмжээний хэлцэл хийх

5.2.5.3 хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

5.2.5.4 нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй

5.2.6 энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх

5.2.7 компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах

5.2.8 энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх

5.2.9 энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах

5.2.10 компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон энэ дүрмийн 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах

5.2.11 хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх

5.3 Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

5.3.1 хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх

5.3.2 нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах

5.3.3 энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр хүргүүлнэ;

5.4 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

# АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

4.7 Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.

4.8 Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

4.9 Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.

4.10 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:

4.10.1 хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;
4.10.2 хувьцаа нэмж гаргах замаар;
4.10.3 өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

### ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

5.2 Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх

5.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах

5.2.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх

5.2.4 Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх

5.2.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах

### "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ЗУРГАА. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ ГАРГАХ ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

6.1 Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болох бөгөөд тус шийдвэрийг ТУЗ-ийн хурал гаргана.

6.2 Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

6.3 Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

6.4 Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ тогтооно.

6.5 Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

6.6 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болно.

6.7 Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна.

6.8 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

6.9 Гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно.

6.10 Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

# АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх журам" болон холбогдох журмаар зохицуулна.

7.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4 Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хурал даргалагчийг сонгоно.

7.6 Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй.

7.7 Компанийн тухай хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.8 Компанийн тухай хуулийн 62.1.7-62.1.16-д заасан асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.9 Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

7.10 ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Санхүүгийн Зохицуулах хорооноос баталсан "Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам"-ын дагуу явуулна.

7.11 Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

7.12 Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

7.13 Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.

7.14 Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.

7.15 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн тус бүр нэг хувийг гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

7.16 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.

7.17 Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

7.18 Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллгын комисс хариуцан гүйцэтгэнэ.

7.19 Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.

7.20 ТУЗ нь энэхүү дүрмийн 7.19-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.

## “АЙТҮҮЛС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

**Төлөөлөн удирдах зөвлөл**

7.21 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргын эрх, үүрэг, ТУЗ-ийн гишүүдийн саналын эрх, хурлын санал хураалт зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

7.22 Компанийн ТУЗ нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 (зургаа) нь ердийн, 3 (гурав) нь энэ дүрмийн 7.25-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.

7.23 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 1 (нэг) жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.

7.24 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1.1-79.1.5-д зааснаас гадна шалгуурыг хангасан этгээд байна:

7.24.1 Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй;

7.24.2 Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

7.24.3 Компанийн хараат, охин компани, компанийн нэгдэлд хамаарах компанид сүүлийн 3 жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;

7.24.4 Компанийн өрсөлдөгч, ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш.

7.25 ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

7.26 ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ:

7.26.1 компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

7.26.2 ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;

7.26.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;

7.26.4 хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;

7.26.5 өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.

7.27 ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.1-76.1.18-д болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.27.1 эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

7.27.2 гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах;

7.27.3 компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;

7.27.4 хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

7.28 ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.

7.29 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

7.30 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын алба, хараат бус аудитийн байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

7.31 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй гаргана.

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.32 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

7.33 Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагаар үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагаар явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитийн болон Цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.

7.34 Хороод нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу үйл ажиллагаа явуулна.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

7.35 ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

7.36 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно:

7.36.1 компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;

7.36.2 бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;

7.36.3 Хувьцаа эзэмшигчдын хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.36.4 компанийн ТУЗ нь гүйцэтгэх албаны хэлтэс газрууд үр дүнтэй мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;

7.36.5 мэдээлэлийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

7.36.6 хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, компани доторхи маргааныг шийдвэрлэх талаар холбогдорх арга хэмжээ авах, санал боловсруулах;

7.36.7 хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээд Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;

7.36.8 компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачлагыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

7.37 ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.37.1 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;

7.37.2 компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтигй хянах, холбогдох этгээдээс шаардах;

7.37.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шидвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр сууртай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;

7.37.4 компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

**Гүйцэтгэх удирдлага**

7.38 Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид "гүйцэтгэх захирал" гэж нэрлэх) нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

7.39 Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

7.40 Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ.

7.41 ТУЗ компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийн төлөөлөн дарга гарын үсэг зурна.

7.42 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байх эсхүл компанитай хамааралгүй өөр байгууллагад давхар ажиллахыг хориглоно.

7.43 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. Үүнд:

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.43.1 компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

7.43.2 хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;

7.43.3 компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;

7.43.4 компанийн дотоод журмыг батална;

7.43.5 өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;

7.43.6 компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;

7.43.7 компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;

7.43.8 компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

7.43.9 Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулах;

7.43.10 компанийн түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;

7.43.11 компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;

7.43.12 хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

7.43.13 компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулин 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.

7.44 Компанийн ТУЗ нь гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь хэдийд ч чөлөөлөх эрхтэй. Түүнийг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

7.45 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.

### НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦЛАГА

8.1 ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэнгүүд, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

8.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84.4, 84.5, 85.1 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ.

8.3 Албан тушаалтан энэ дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн Компанийн тухай хуулийн 85.2, 85.3-т заасан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

8.4 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## ЕС. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

**Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан**

9.1 Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

9.2 Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

9.3 Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.

9.4 Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1, 97.2-т заасан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцна.

9.5 Энэ дүрмийн 9.4-т заасан бичиг баримтыг 5 жил хадгалаад архивт шилжүүлнэ. Харин компанийн дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг байнга хадгална.

9.6 Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

9.7 Компанийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байхаас гадна дараах мэдээллийг агуулсан байна:

9.7.1 тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

9.7.2 эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр;

9.7.3 санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга.

9.8 Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталагдсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

9.9 Компанийн гүйцэтгэх захирал нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитийн болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар мэдээлэлтэй тайлантай танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

## АРАВ. НОГДОЛ АШИГ

10.1 Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.

10.2 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

10.3 Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

10.3.1 ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

10.3.2 ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

10.3.3 компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

10.4 Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.5 Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

### "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

10.6 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

10.7 Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

10.8 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.

10.9 Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

### АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

**Дотоод хяналт**

11.1 Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитийн хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

11.2 Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

11.3 Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

**Аудиторын /хөндлөнгийн/ хяналт**

11.4 Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.

11.5 Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитийн шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

11.6 Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

11.7 Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитийн хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.

### АРВАН ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

12.1 Компанийн үйл ажиллагаанд гарч болох компани түүний бизнесийн түншүүд (зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч гэх мэт), ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байна.

12.2 Аливаа зөрчил, маргаан үүссэн үед компанийн эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны удирдлагад танилцуулна.

12.3 Энэ дүрмийн 12.2-т заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.

12.4 Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцохгүй.

12.5 Компани нь Компанийн тухай хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална:

## АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

### "АЙТҮҮЛС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### АРВАН ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

12.5.1 компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцэлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон аудитийн хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;

12.5.2 хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтоохол хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;

12.5.3 хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонихрлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид хохирол учруулсан бол эрх бүхий албан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

12.5.4 Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

### АРВАН ГУРАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

13.1 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

13.2 Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

13.2.1 компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

13.2.2 хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн;

13.2.3 Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр;

### АРВАНДӨРӨВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

14.1 Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

14.2 Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 14.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

**Айтүүлс ХК** нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахад анхаарал хандуулж, компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд тайлагнан ажилладаг.

**Айтүүлс ХК** нь 2017 оны 11 дүгээр сард нийт хувьцааны 38.61%-ийг олон нийтэд нээлттэй санал болгосон ба 2018 онд стратегийн хөрөнгө оруулагчид нэмэгдэж мөн оны жилийн эцсийг байдлаар хувьцаа эзэмшилт нь дараах бүтэцтэй болсон.




## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Айтүүлс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компанийн эрх барих дээд байгууллага юм.

Хувьцаа эзэмшигдийн хурал нийт 3 удаа хуралдсан байна.

### АНХДУГААР ХУРАЛ

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 63.3%-ийн ирцтэйгээр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Анхдагч зах зээлийн тухай танилцуулгыг хийсэн
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон
- Компанийн дүрмийг шинэчилэн баталсан

### ЭЭЛЖИТ ХУРАЛ

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 21,155,025 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 61.4%-ийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлийг баталсан
- Компанийн хэрэгжүүлж буй төсөл бүрэн дуусаагүйн зэрэгцээ компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2017 оны ашгаас ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсан
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг танилцуулсан.

### ЭЭЛЖИТ ХУРАЛ

2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15 цагт МҮТП-ын хурлын танхимд 52.9%-ийн ирцтэйгээр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулсан
- Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулсан
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох, төсвийг батлах
- “Синэт” ХХК-ийн хувьцааг худалдан авах тухай тус тус хэлэлцэж баталсан.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн үйл ажиллагааг зохистой төвшинд удирдах, стратегийн зорилтод хүрэхэд хяналт тавин ажиллаж байгаагийн зэрэгцээ гүйцэтгэх удирдлагыг компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

ТУЗ нь дэргэдээ Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг бүхий дараах 3 хороотой ба хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан шаардлагын дагуу ТУЗ-өөс томилдог.

## АУДИТИЙН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавихад оршино.



Аудитын хорооны дарга
**З. МЯГМАРСҮРЭН**



ТУЗ-ийн ердийн гишүүн
**Н. УЛААНХҮҮ**



ТУЗ-ийн хараат бус гишүүн
**Л. ТЭМҮҮЛЭЛ**

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.



ТУЗ-ийн хараат бус гишүүн
**Л. ТЭМҮҮЛЭЛ**



ТУЗ-ийн дарга
**А. БАТТАМИР**



ТУЗ-ийн хараат бус гишүүн
**Э. НАРАНМӨНХ**

## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.



ТУЗ-ийн хорооны дарга
**Г. ХАТАНБОЛД**



ТУЗ-ийн хараат бус гишүүн
**З. МЯГМАРСҮРЭН**



ТУЗ-ийн хараат бус гишүүн
**Д. ДАВАА**

# ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



ТУЗ-ийн дарга

**А. БАТТАМИР**

- Техникийн ухааны магистр
- Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Д. ДАВАА**

- Програм хангамжийн инженер
- ККТТ ХХК-ийн Бизнес хариуцсан захирал
- Цалин урамшууллын хорооны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**З. МЯГМАРСҮРЭН**

- Зах зээл судлаач, эдийн засагч
- Бодь тусгал Аудит ХХК-ийн захирал
- Аудитын хорооны дарга, цалин урамшууллын хорооны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Э. НАРАНМӨНХ**

- Програм хангамжийн инженер
- Грийнсофт ХХК-ийн Борлуулалт, маркетингийн албаны дарга
- Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Л. ТЭМҮҮЛЭЛ**

- Эрх зүйн ухааны магистр
- Тэлмэн хас ББСБ-ийн хувьцаа эзэмшигч
- Нэр дэвшүүлэх хорооны дарга, аудитын хорооны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн

**Н. УЛААНХҮҮ**

- Эдийн засгийн онолч, эдийн засагч
- Аудитын хорооны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн

**Г. ХАТАНБОЛД**

- Санхүүгийн удирдлагын магистр
- Дижитал эксчейнж монголиа ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Цалин урамшууллын хорооны дарга



ТУЗ-ийн ердийн гишүүн

**Б. ЭРДЭНЭЖАРГАЛ**

- Бизнесийн удирдлага
- Стандарт инвестмент ҮЦК ХХК-д диллер



ТУЗ-ийн ердийн гишүүн

**Б. ТАМИР**

- Улс төрийн удирдлагын магистр
- Айтүүлс ХК-ын гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

**Б. АРИУНЗУЛ**

- ОУ-ын эдийн засаг, худалдаа

# ТУЗ-ИЙН ХУРАЛ

1) "Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал **2019 оны 01 дүгээр сарын 18**-ны өдөр болж өндөрлөлөө.

Тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн байна.

- Айтүүлс ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг танилцуулах
- Санхүүгийн аудитын компанийг сонгох тухай
- Модуляр дата төвийн парк төслийн гүйцэтгэлийг шуурхайлуулах талаар авах зарим арга хэмжээний тухай
- Ноогдол ашиг хувиарлах эсэхийг хэлэлцэж шийдвэрлэсэн.



2018 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гаргасан байна.

2) ТУЗ-ийн ээлжит хурал **2019 оны 02 дугаар сарын 21**-ний өдөр хуралдаж АйСиТи групп ХХК-ийн Хаан банкнаас авах зээлийн гэрээнд хамтран үүрэг гүйцэтгэгчээр орох гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох тухай хэлэлцэв. ТУЗ-ийн гишүүд асуудлыг 100% дэмжиж зээлийн гэрээнд хамтран үүрэг гүйцэтгэгчээр орох гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгохоор шийдвэрлэв.

3) "Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал **2019 оны 03 дугаар сарын 15**-ны өдөр хуралдаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов тогтоох тухай, хурлаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулах мэдээлэл, хурлаас гарах шийдвэрийн төсөл зэргийг хэлэлцэж батлав.



4) ТУЗ-ийн ээлжит хурал **2019 оны 07 дугаар сарын 26**-ны өдөр болж

- Гүйцэтгэх захирлын ажлын тайлан, гүйцэтгэх захирлын гэрээг сунгах тухай
- Хагас жилийн санхүүгийн тайлан
- Модуляр дата төвийн паркийн доторх контейнэр дата төвийн хөрөнгийн зарцуулалтын тухай тус тус хэлэлцэв.

5) Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо **2019 оны 11 дүгээр сарын 14**-ний өдөр онлайнаар хуралдав. Хурлаар Б. Тамирыг жирэмсний болон амаржсаны амралтаа авах болсонтой холбоотой гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгчийг томилон ажиллуулах тухай хэлэлцэж Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгчид нэр дэвших хүсэлтэй нэр дэвшигчдийн анкетийг хүлээн авч ТУЗ-д танилцуулан онлайнаар санал авч гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгчийг томилохоор шийдвэрлэв.



6) ТУЗ-ийн ээлжит хурал **2019 оны 11 дүгээр сарын 28**-ны өдөр онлайнаар хуралдаж Гүйцэтгэх захирал Б. Тамирт жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай хэлэлцэж.

Гүйцтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай хэлэлцэж Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Айтүүлс ХК-ийн Технологи хариуцсан захирал У. Номинг томилохоор шийдвэрлэв.

Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл **2019** онд нийт **5** удаа, Нэр дэвшүүлэх хороо **1** удаа хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд нийт **11** асуудал хэлэлцэж шийдвэрлэн, **9** тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагаа чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.

# КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



Гүйцэтгэх захирал

**Б. ТАМИР**

- Саман-Ёлу ХХК-д Захирлын туслах, Эмпати-Ертөнц ХХК-д нягтлан бодогч
- Улаанбаатар-Элит ОУДС-д нягтлан бодогч
- ТЕГ-ын дэргэдэх НӨАТ-ын төсөл Ерөнхий санхүүч
- Гааль Татварын мэдээллийн технологийн төв УТҮГ-т олон нийттэй харилцах мэргэжилтэн
- Эмпасофт ХХК-д сургалт хариуцсан менежерээр
- 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ТУЗ-ийн 2018 оны 09 тоот тогтоолоор "Айтүүлс" ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



Ерөнхий нягтлан бодогч

**Б. ӨНӨРБАДРАХ**

- Жэттрак ХХК-д Тооцооны нягтлан бодогч
- Жэткидс ХХК-д Нягтлан бодогч
- Монгол Эм Импекс Концерн ХХК-д Нягтлан бодогч
- Айтүүлс ХК-д Нягтлан бодогчоор 2019 оны 04 дүгээр сараас эхлэн ажиллаж байна.



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

**Б. АРИУНЗУЛ**

- БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвд Дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
- Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар 2018 оны 02 дугаар сараас хойш ажиллаж байна.

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Айтүүлс ХК-ийн хувьцаа 2019 онд 125 удаагийн арилжаа хийгдэж нийт **124,283,803** төгрөгийн **1,348,954** ширхэг хувьцаа арилжигдсан байна. Нэг удаагийн арилжааны дундаж дүн **994,270** төгрөг байна.







Хувьцааны ханш 2019 оны 01 дүгээр сард 104 төгрөгийн үнэтэй байсан бол 2019 оны 12 дугаар сард 75 төгрөг болж буурсан үзүүлэлттэй байна.

**МАНАЙ КОМПАНИЙН НЭГЖ ХУВЬЦААНЫ ДАНСНЫ ҮНЭ:**

2017 оны III улиралд буюу анх нээлттэй ХК болох үед 41.69 төгрөг

2018 оны IV улиралд 86.89 төгрөг

2019 оны IV улиралд 92.87 төгрөг болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ТӨСӨЛ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

_____ оны ___ сарын ___ өдөр        Дугаар ____        Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэхь заалт, "Айтүүлс" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Айтүүлс" ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд

Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

# ТӨСӨЛ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

_____ оны ___ сарын ___ өдөр Дугаар ____ Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Ердийн гишүүд:

1.
2.
3.
4.
5.
6.

Хараат бус гишүүд:

1.
2.
3.

ХУРЛЫН ДАРГА

# ТӨСӨЛ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

_____ оны ___ сарын ___ өдөр Дугаар ____ Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн цалин, урамшууллын төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, "Айтүүлс" ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны болон гишүүдийн цалин урамшууллыг 43.010.000 /дөчин гурван сая арван мянган/ төгрөгөөр батлсугай.

2. Төсвийн задаргааг хавсралтаар батлсугай.

ХУРЛЫН ДАРГА

# ТӨСӨЛ

Айтүүлс ХК-ийн ХЭХурлын 2020 оны
04 дугаар сарын 29-ний өдрийн хурлын
..... дугаартай тогтоолын 1-р хавсралт

**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

| # | ҮЙЛ АЖИЛЛАГАА | ЖИЛИЙН ЗАРДАЛ |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны зардал | 350,000 ₮ |
| 2 | ТУЗ-ийн гишүүдийн цалин | 29.160.000 ₮ |
| 3 | ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин | 13.500.000 ₮ |
| | **Нийт дүн** | **43.010.000 ₮** |

# ТӨСӨЛ

**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

_____ оны ___ сарын ___ өдөр    Дугаар ____    Улаанбаатар хот

Компанийн дүрмийг шинэчилэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.1 дэхь заалт, “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

2. Шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, бусад холбогдох байгууллагад хүргүүлж баталгаажуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Ариунзул /РД: ЙС90052127/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

# ТӨСӨЛ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

_____ оны ___ сарын ___ өдөр                Дугаар ____                Улаанбаатар хот

### Их хэмжээний хэлцэл хийх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 1, 2 дахь заалт, "Айтүүлс" ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Айсити групп" ХК-ийн өмчлөлд буй Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р багт байрлах 1,110,000,000 /нэг тэрбум нэг зуун арван сая/ төгрөгийн үнэлгээ бүхий үйлдвэрлэлийн зориулалттай обьектийг /4300 мкв газрын хамт/, Дархан хотод модуляр дата төвийн зориулалтаар захиалан бариулж буй 930,000,000 /есөн зуун гучин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий дуусаагүй барилга /2500 мкв газрын хамт/-тай солих саналыг хүлээн авч шийдвэрлэсүгэй.

2. Дээрх хэлцлийг хийх эрхийг Гүйцэтгэх захирал /Б. Тамир/-д олгосугай.

3. Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу дээрх хэлцлийн үр дүнг нийтэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /А. Баттамир/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

САНАЛЫН ХУУДАС

# САНАЛЫН ХУУДАС

Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны
03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
..... дугаартай тогтоолын 1-р хавсралт

**"АЙТҮҮЛС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ____________________
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: ____________________
Регистерийн дугаар: ____________________
Санал өгөх хувьцааны тоо: ____________________
Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: ____________________
Брокерийн овог, нэр: ____________________

"Айтүүлс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн 15.00 цагт онлайнаар зохион байгуулагдана.

| # | ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД | ЗӨВШӨӨРСӨН | ТАТГАЛЗСАН | ТҮДГЭЛЗСЭН | ТАТГАЛЗСАН ТОХИОЛДОЛД ТАНЫ ӨГӨХ САНАЛ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах | | | | |
| 2 | Компанийн дүрмийг шинэчилэн батлах | | | | |
| 3 | ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлах | | | | |
| 4 | Их хэмжээний хэлцэл хийх тухай тогтоолын төслийг батлах | | | | |

Хувьцаа эзэмшигч ...................................................... /гарын үсэг/

Огноо: _____ оны __ сарын __ өдөр

САНАЛЫН ХУУДАС

# САНАЛЫН ХУУДАС

Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны
03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
..... дугаартай тогтоолын 2-р хавсралт

**"АЙТҮҮЛС " ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ**
**ТУЗ -Д НЭР ДЭВШИГЧИДИЙН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ____________________

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: ____________________

Регистерийн дугаар: ____________________

Санал өгөх хувьцааны тоо: ____________________

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: ____________________

Брокерийн овог, нэр: ____________________

| # | ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС | НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО |
|---|---|---|
| 1 | Ердийн гишүүд | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |
| | Хараат бус гишүүд | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |

Брокер ..................................................... /гарын үсэг/
/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч ..................................................... /гарын үсэг/

Огноо: ____ оны __ сарын __ өдөр

**ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.** Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшидэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 99059722 утсаар лавлаж болно.
4. Санал авах хуудас хүчингүй болсон тухай шалтгаан